



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/073/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэбүрэн хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

᠒᠐25.02.24. № 2/᠒4

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЗЭРЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.АРИУНБОЛД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.1.3, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлээгүй
- Газрын үндсэн хөрөнгөнд ангилж бүртгээгүй, газраа кадастрын зургийн дагуу бүртгээгүй мэдээллийн санд оруулж төлбөрийн ногдуулалт хийгээгүй,
- Зэрэг сумын 100 жилийн ойн хандивын бэлэн мөнгөөр болон материалаар орж ирсэн хөрөнгийн тооцоо хийгээгүй, бэлэн зарцуулсан 243.0 сая, 16.2 сая төгрөгийн хандивын мал бүртгэж орлого аваагүй, тайланд тусгаагүй 259,208.2 мянган төгрөгийн зөрчил,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хандиваар ирсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй ИТХ-аар тогтоол шийдвэр гаргуулаагүй 46,425.6 мянган төгрөгийн хөрөнгө орлого аваагүй,
- Спортын ордны заалны түрээсийн орлого тооцоогүй, шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, бараа материалын тооллого хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 27,889.7 мянган төгрөгийн шатахууны тооцоо хийгээгүй зөрчлүүд илэрсэн.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Зэрэг сумын ЗДТГ нь 100 жилийн ойн арга хэмжээнд бэлэн зарцуулсан 58,773.0 мянга, 16,200.0 мянган төгрөгийн хандивын мал, 184,235.2 мянган төгрөгийн бараа материалыг тайланд тусгаагүй, тайлант оны хөрөнгийн тооллого хийгээгүй, спорт заалны түрээсийн орлогын тооцоо хийгээгүй, хөрөнгө орлого авах ИТХ-ын тогтоол шийдвэр гаргаагүй байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Зэрэг сумын ЗДТГ нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлэг 10 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнан сумын Засаг даргаар дүгнүүлсэн ч гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>111,880,658.00</u></b>	<b><u>142,268,366.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	17,659,498.00	18,443,536.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	17,659,498.00	18,443,536.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	57,581,160.00	85,344,830.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	48,914,160.00	76,677,830.00
35410	Бичиг хэргийн материал	1,709,725.00	1,829,725.00
35420	Аж ахуйн материал	405,000.00	578,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,553,200.00	6,481,300.00
35470	Бусад хангамжийн материал	43,246,235.00	67,788,805.00
35600	Мал амьтад	8,667,000.00	8,667,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	36,640,000.00	38,480,000.00
36300	Тэжээлийн нөөц	36,640,000.00	38,480,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,762,080,967.07</u></b>	<b><u>8,491,438,481.26</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,762,080,967.07	8,491,438,481.26
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,755,663,216.99	8,485,020,731.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,924,512,420.50	8,755,005,854.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,370,860,843.43)	(1,556,467,163.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	156,549,950.00	314,599,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(95,372,882.27)	(92,164,548.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,665,580,603.10	1,703,843,668.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(598,627,385.17)	(764,268,278.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,676,521.00	162,466,521.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,955,666.74)	(38,155,772.33)
39217	Ном	160,500.00	160,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,417,750.08	6,417,750.08
39301	Програм хангамж	1,207,000.00	1,207,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(905,249.92)	(905,249.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,116,000.00	6,116,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,873,961,625.07</u></b>	<b><u>8,633,706,847.26</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>17,659,498.00</u></b>	<b><u>3,329,396.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	17,659,498.00	3,329,396.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	17,659,498.00	3,329,396.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,329,396.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	17,659,498.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	(18,443,536.00)
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	17,659,498.00	18,443,536.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,856,302,127.38</u></b>	<b><u>8,630,377,451.26</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,856,302,127.38	8,630,377,451.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	494,395,716.00	494,395,716.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	7,276,054,114.41	8,050,129,438.29
51210	Өмнөх үеийн үр дүн	7,276,054,114.41	7,276,054,114.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	774,075,323.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,852,296.97	85,852,296.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,873,961,625.38</u></b>	<b><u>8,633,706,847.26</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,607,500,898.60</b>	<b>2,549,700,557.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,755,296,878.60</b>	<b>644,445,997.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,755,296,878.60	644,445,997.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,755,296,878.60	644,445,997.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,755,296,878.60	644,445,997.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>852,204,020.00</b>	<b>1,905,254,560.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	231,881,920.00	710,415,360.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	693,697,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	214,951,025.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,930,895.00	16,717,410.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	620,322,100.00	1,194,839,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	620,322,100.00	1,194,839,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,237,595,519.85</b>	<b>1,775,625,233.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,113,946,679.85</b>	<b>1,524,777,766.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,090,396,100.22	1,429,241,692.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	424,447,810.00	668,374,837.00
210101	Үндсэн цалин	233,662,056.00	389,457,833.00
210102	Нэмэгдэл	122,493,354.00	234,486,884.00
210104	Урамшуулал	19,033,887.00	13,870,120.00
210105	Гэрээт ажлын хөлс	49,258,513.00	30,560,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,438,390.00	87,802,553.00
210201	Тэтгэврийн даатгал	34,441,700.00	61,935,832.45
210202	Тэтгэмжийн даатгал	4,239,000.00	6,677,986.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,391,200.00	3,338,993.29
210204	Ажилгүйдлийн даатгал	847,800.00	3,169,946.54
210205	Эрүүл мэндийн даатгал	9,518,690.00	12,679,794.34
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,276,099.64	183,513,795.25
210301	Гэрэл, цахилгаан	8,918,099.64	10,663,599.25
210302	Түлш, халаалт	61,958,000.00	159,720,800.00
210303	Цэвэр, бохир ус	7,400,000.00	13,129,396.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,057,820.73	35,678,473.00
210401	Бичиг хэрэг	2,687,400.00	2,634,400.00
210402	Тээвэр, шатахуун	24,480,008.00	29,406,222.00

**Зэрэг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,412.73	3,637,851.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	513,000.00	480,665.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	513,000.00	480,665.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,435,000.00	3,810,100.00
210604	Урсгал засвар	1,435,000.00	3,810,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,671,142.00	8,569,900.00
210702	Дотоод албан томилолт	7,671,142.00	8,569,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,047,306.00	33,907,619.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,048,500.00	32,456,230.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,334.00	69,360.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.00	735,000.00
210807	Газрын төлбөр	122,472.00	301,029.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	485,509,531.85	407,103,749.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,231,360.00	33,580,765.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	471,600.00	1,334,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	423,806,571.85	372,188,984.81
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,550,579.63	95,536,074.06
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,745,000.00	74,647,400.31
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,577,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	1,400,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	21,805,579.63	20,888,673.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,805,579.63	20,888,673.75
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>123,648,840.00</b>	<b>250,847,467.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	123,648,840.00	250,847,467.00
220001	Барилга байгууламж	123,648,840.00	250,847,467.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,369,905,378.75</b>	<b>774,075,323.88</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,369,905,378.75</b>	<b>774,075,323.88</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>852,204,020.00</b>	<b>2,527,385,637.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>852,204,020.00</b>	<b>2,527,385,637.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	231,881,920.00	1,332,546,437.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	693,697,950.00

Зэрэг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	214,951,025.00	615,397,536.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,930,895.00	23,450,951.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>620,322,100.00</b>	<b>1,194,839,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	620,322,100.00	1,194,839,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>729,160,180.00</b>	<b>1,940,863,733.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>729,160,180.00</b>	<b>1,940,863,733.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>705,609,600.37</b>	<b>1,844,982,659.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>424,447,810.00</b>	<b>667,961,241.00</b>
210101	Үндсэн цалин	233,662,056.00	363,199,281.00
210102	Нэмэгдэл	122,493,354.00	258,565,190.00
210104	Урамшуулал	19,033,887.00	17,011,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	49,258,513.00	29,185,070.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,438,390.00</b>	<b>83,324,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,441,700.00	56,790,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,239,000.00	6,639,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,391,200.00	5,321,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	847,800.00	2,076,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,518,690.00	12,495,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>78,276,099.64</b>	<b>180,184,399.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,918,099.64	10,663,599.25
210302	Түлш, халаалт	61,958,000.00	159,720,800.00
210303	Цэвэр, бохир ус	7,400,000.00	9,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,123,052.73</b>	<b>26,508,461.00</b>
210401	Бичиг хэрэг	2,237,400.00	2,754,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,995,240.00	20,116,210.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,890,412.73	3,637,851.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>501,100.00</b>	<b>480,665.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	501,100.00	480,665.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,685,600.00</b>	<b>7,668,700.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,900.00	-
210604	Урсгал засвар	1,673,700.00	7,668,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,671,142.00</b>	<b>9,149,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,671,142.00	9,149,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,723,446.00</b>	<b>759,438,008.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,724,640.00	757,986,619.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	196,334.00	69,360.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.00	735,000.00
210807	Газрын төлбөр	122,472.00	301,029.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,742,960.00</b>	<b>110,266,885.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78,042,960.00	108,782,885.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	1,484,000.00

**Зэрэг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,550,579.63</b>	<b>95,881,073.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,745,000.00	74,992,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,577,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	41,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	1,745,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	21,805,579.63	20,888,673.75
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,805,579.63	20,888,673.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>123,043,840.00</u></b>	<b><u>586,521,904.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>123,648,840.00</b>	<b>586,521,904.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>123,648,840.00</b>	<b>586,521,904.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	123,648,840.00	586,521,904.00
220001	Барилга байгууламж	123,648,840.00	573,364,904.00
222001	Тоног төхөөрөмж	-	13,157,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(123,648,840.00)</u></b>	<b><u>(586,521,904.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(605,000.00)	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	494,395,716.00	85,852,296.97	3,905,543,738.35	4,485,791,751.32
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	279,589.50	279,589.50
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>494,395,716.00</b>	<b>85,852,296.97</b>	<b>3,905,823,327.85</b>	4,486,071,340.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(279,589.50)	-	(279,589.50)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	3,370,510,376.06	3,370,510,376.06
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>494,395,716.00</b>	<b>85,572,707.47</b>	<b>7,276,333,703.91</b>	7,856,302,127.38

D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	494,395,716.00	85,572,707.47	7,276,333,703.91	7,856,302,127.38
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,395,716.00	85,572,707.47	7,276,333,703.91	7,856,302,127.38
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	774,075,323.88	774,075,323.88
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,395,716.00	85,572,707.47	8,050,409,027.79	8,630,377,451.26

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,199,493,560.00	1,196,443,872.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,186,336,560.00	1,183,286,872.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,111,344,160.00	1,108,294,472.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	670,969,879.00	667,961,241.00
210101	Үндсэн цалин	363,199,281.00	363,199,281.00
210102	Нэмэгдэл	259,544,138.00	258,565,190.00
210104	Урамшуулал	17,011,700.00	17,011,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,214,760.00	29,185,070.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,365,900.00	83,324,400.00
210201	Тэтгэврийн даатгал	56,790,800.00	56,790,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,681,200.00	6,639,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,305,000.00	5,321,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,326,300.00	2,076,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,262,600.00	12,495,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	180,184,399.00	180,184,399.00
210301	Гэрэл, цахилгаан	10,663,599.00	10,663,599.00
210302	Түлш, халаалт	159,720,800.00	159,720,800.00
210303	Цэвэр, бохир ус	9,800,000.00	9,800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,669,451.00	23,130,621.00
210401	Бичиг хэрэг	2,754,400.00	2,754,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,277,200.00	16,738,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,637,851.00	3,637,851.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	480,665.00	480,665.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	480,665.00	480,665.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,668,700.00	7,668,700.00
210604	Урсгал засвар	7,668,700.00	7,668,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,569,900.00	9,149,900.00
210702	Дотоод албан томилолт	8,569,900.00	9,149,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	67,415,866.00	67,415,866.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,964,477.00	65,964,477.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	346,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,360.00	69,360.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	735,000.00	735,000.00

**Зэрэг сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210807	Газрын төлбөр	301,029.00	301,029.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70,019,400.00</b>	<b>68,978,680.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,535,400.00	67,494,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	1,484,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>74,992,400.00</b>	<b>74,992,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>74,992,400.00</b>	<b>74,992,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,577,400.00	31,577,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,670,000.00	41,670,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	1,745,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,157,000.00</b>	<b>13,157,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,157,000.00</b>	<b>13,157,000.00</b>
222001	Тоног төхөөрөмж	13,157,000.00	13,157,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,199,493,560.00</b>	<b>1,196,443,872.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,198,888,560.00</b>	<b>1,194,839,200.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,198,888,560.00	1,194,839,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>605,000.00</b>	<b>1,604,672.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	1,604,672.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл (Төгрөгөөр)
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,328,496,627.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>742,740,682.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>742,740,682.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,877,840.00</b>
210402	Тээвэр, шатахуун	6,877,840.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,571,292.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,571,292.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>719,946,990.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	719,946,990.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,344,560.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,344,560.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>18,443,536.00</b>

213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	18,443,536.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>585,755,945.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	585,755,945.00
220001	Барилга байгууламж	585,755,945.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,328,496,627.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,328,496,627.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	693,697,950.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	585,755,945.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,132,632.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,910,100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 958,099.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 624,575.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн үр дүнд 607,180.6 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн,
- Мөнгөн хөрөнгийн тайланд 14,950.4 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,444.7 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн, нэмэлт төсвийн гүйцэтгэл тайлагнаагүй зөрчлүүдийг залруулсан

Залруулагдаагүй 333,523.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 333,523.5 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, ойн хандивтай холбоотой 1 албан шаардлага, хөрөнгийн тооллого хийх, заалны орлого тооцох, шатахууны зардалтай холбоотой зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Илрүүлэлт: Зэрэг сумын 100 жилийн ойн хандивын бэлэн мөнгөөр болон материалаар орж ирсэн хөрөнгийн тооцоо хийгээгүй, бэлэн зарцуулсан 243.0 сая, хандивын мал бүртгэж орлого аваагүй 16.2 сая төгрөгийг тайланд тусгаагүй нийт 259,208.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.2.1 Газрын мэдээллийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Газрын үндсэн хөрөнгөнд ангилж бүртгээгүй, газраа кадастрын зургийн дагуу бүртгээгүй мэдээллийн санд оруулж төлбөрийн ногдуулалт хийгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь УСНББОУС-1, УСНББОУС31 Биет бус хөрөнгө АДБОУС 200,2000, MNS-6817-4:2020 стандартын 7.1.1.2.2, 7.1.3.4, 7.1.3.5 заалтууд болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын бүртгэлийг мэдээллийн санд оруулж, төлбөрийн ногдуулалт хийж мэдээллийн санд оруулах

### 5.2.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хандиваар ирсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй ИТХ-аар тогтоол шийдвэр гаргуулаагүй, дутагдалтай хөрөнгө болон элэгдлээ нөхсөн хөрөнгөд тавих хяналт сул 46,425.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хариуцлагатай хандаж хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгийн тооллого иж бүрэн хийх

### 5.3.4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Спортын ордны заалны түрээсийн орлого тооцоогүй, шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, бараа материалын тооллого хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, бэлэн зарцуулсан мөнгөний баримт хангалтгүй 27,889.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Ойгоор ирсэн хөрөнгөд тооллого хийх, спорт заалны түрээсийн орлого тооцох, түрээсийн гэрээ байгуулах, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн үр дүнд 607,180.6 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн	1	607,180.6			1	607,180.6	1	607,180.6	-	-
Мөнгөн хөрөнгийн тайланд 14,950.4 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн,	1	14,950.4			1	14,950.4	1	14,950.4		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,444.7 мянган төгрөгийн орлого буруу илэрхийлсэн, нэмэлт төсвийн гүйцэтгэл тайлагнаагүй зөрчлүүдийг залруулсан	1	2,444.7			1	2,444.7	1	2,444.7		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>624,575.7</b>			<b>3</b>	<b>624,575.7</b>	<b>3</b>	<b>624,575.7</b>		

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Газрын үндсэн хөрөнгөнд ангилж бүртгээгүй, газраа кадастрын зургийн дагуу бүртгээгүй мэдээллийн санд оруулж төлбөрийн ногдуулалт хийгээгүй	1	0					1	
Зэрэг сумын 100 жилийн ойн хандивын бэлэн мөнгөөр болон материалаар орж ирсэн хөрөнгийн тооцоо хийгээгүй, бэлэн зарцуулсан 243.0 сая, 16.2 сая төгрөгийн хандивын мал бүртгэж орлого аваагүй, тайлан баланст тусгаагүй	1				1	259,208.2		

Зэрэг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хандиваар ирсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй ИТХ-аар тогтоол шийдвэр гаргуулаагүй, дутагдалтай хөрөнгө болон элэгдлээ нөхсөн хөрөнгөд тавих хяналт сул	1	46,425.6				1	46,425.6
Спортын ордны заалны түрээсийн орлого тооцоогүй, шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, бараа материалын тооллого хийгээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, бэлэн зарцуулсан мөнгөний баримт хангалтгүй	1	27,889.7				1	27,889.7
Дүн	4	333,523.5			1	259,208.2	3 74,315.3

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Х.БОЛДБААТАР 2025.02.25

АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН 2025.02.25

ГЭРЭЭТ АУДИТОР *[Signature]* Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ 2025.02.25